


**ОСЛЫН ГАЗАР ДЭЭРХ ХӨДӨЛМӨРИЙН  
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР  
/HAZARDS AT AIRCRAFT ACCIDENT SITES/**





## ОСЛЫН ГАЗАР ДЭЭРХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

### ГАРЧИГ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
2. НИЙТЛЭГ ШААРДЛАГА
3. НИЙТЛЭГ ХОРИГЛОХ ЗҮЙЛС
4. ГАЛЫН АЮУЛТАЙ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
5. АЮУЛТАЙ АЧААТАЙ ХАРЬЦАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
6. ОСЛЫН ҮЙЛДЭГДЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
7. БИОЛОГИЙН АЮУЛТАЙ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
8. НИСДЭГ ТЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН ЦАГ АГААРЫН АЮУЛТАЙ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
10. ХОРТОЙ УРГАМАЛ, АЮУЛТАЙ АМЬТАД БА ШАВЬЖТАЙ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
11. ХОТ СУУРИН ДАХЬ ОСЛЫН ГАЗАРТ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨГДӨХ АЖИЛЛАГАА

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү заавар нь Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны явцад баримтлах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангуулахад чиглэгдэнэ.

1.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа гэдэг нь нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны явцад агаарын хөлгийн эд анги, техник тоног төхөөрөмж, ослын газарт дээрх үйл ажиллагаанаас шалтгаалан ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт хохирол учруулж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх эдийн засаг, техник технологийн болон зохион байгуулалтын арга хэмжээ орно.

## 2. НИЙТЛЭГ ШААРДЛАГА

2.1. "Ажилтан нь үнэнчээр хөдөлмөрлөх, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил, үүрэгтэй холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг чанд сахин биелүүлэх үүрэгтэй". /МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулиас/

2.2. Шинжээчид, шинжлэн шалгах ажиллагаанд томилогдогсод нь энэ зааврын шаардлагуудыг заавал мөрдөн ажиллана.

2.3. Шинжээчид, шинжлэн шалгах ажиллагаанд томилогдогсод нь нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах ажилд гарахын өмнө шинжлэн шалгах багийн ахлагчаас энэ зааврын 4, 5, 6, 7, 9, 10, 11-р заалтуудын дагуу хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, зааварчилгааны хуудас дээр гарын үсэг зурсан байна.

2.4. Шинээр ажилд орж буй ажилтан албан хаагчид нь анх ажилд орохдоо болон жилд нэг удаа мэргэжил, боловсролын түвшин, ажилласан хугацаанаас үл хамааран энэ заавартай танилцаж, урьдчилсан болон давтан зааварчилгаа авч гарын үсэг зурсан байна.

2.5. Ажлын байрууд нь эмийн сан, ундны цэвэр ус, эрүүл ахуйн бусад хэрэгслээр тоноглогдсон байх ба тэдгээрийг зөвхөн зохиулалтын дагуу ашиглана.

2.6. Хамгаалах хэрэгсэл, бээлийн, ажлын тусгай хувцасыг нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажил гүйцэтгэх үед заавал ашиглана.

2.7. Ослын газар ажиллах үед агаарын хөлгийн болон, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюул ослын эх үүсвэр болж болзошгүй хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй, биологийн аюултай хэрэгслүүд хаалт, хамгаалалтын хэрэгсэл, анхааруулга дохионы хэрэгсэл, бичиг тавьсан байна.

2.8. Гэрэлтүүлэг нь ажлын байранд жигд тархсан гялбаа үүсэхгүй байх шаардлагатай.

2.9. Шинжээч мэргэжилтэн бүр ажлын хувцасны болон гадуур хувцасны шүүгээтэй байна.

2.10. Ажлын байруудад байгаа эмийн сан, хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцасны ашиглалтанд хяналт тавьж, бүрдүүлэлт дутсан тохиолдолд яаралтай захиалга өгөн иж бүрдлийг хангана.

### **3. НИЙТЛЭГ ХОРИГЛОХ ЗҮЙЛС**


3.1. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн ажилтан ажлын байранд ирэх, ажил үүргээ гүйцэтгэхийг хатуу хориглоно.

3.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангахгүй багаж хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг шинжлэн шалгах ажилд ашиглахыг хатуу хориглоно.

3.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа аваагүй ажилтанг ажил гүйцэтгэхийг хориглоно.

### **4. ГАЛЫН АЮУЛТАЙ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

4.1. Ихэнхи агаарын хөлгийн ослын үлдэгдлээс гал гарах эрсдэл өндөр байдаг ба ажилтнуудын аюулгүй байдлыг баталгаажуулах, ослын үлдэгдлийг хамгаалах үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.



4.2. Гал гарах аюул өндөр байгаа нөхцөлд гал унтраах хэрэгслийг бэлэн байдалд байлгах шаардлагатай ба хамгаалалтын бүсэд тамхи татахыг хориглоно.

4.3. Агаарын хөлгийн аккумуляторыг аль болохоор түргэн салгаж түлшний сав нь гэмтээгүй бол юүлэх шаардлагатай.

4.4. Түлшний сав болгоноос юүлсэн түлшийг хэмжиж тэмдэглэж авах шаардлагатай.

4.5. Их хэмжээний түлш асгарсан бол шинжлэн шалгагч нь ослын үлдэгдлийг зөөх гэх мэт гал авалцах боломжийг ихэсгэсэн аливаа ажиллагааг хянах статик цахилгаан гэх мэт гал авалцах боломжтой зүйлүүдийг анхааралтай хянах шаардлагатай.

4.6. Галын аюулыг үнэлэн арилгах хүртэл радио юм уу цахилгаан хэрэгслийг ажиллуулах эсвэл аврах төхөөрөмжийг ашиглахаас зайлсхийх нь зүйтэй.

## **5. АЮУЛТАЙ АЧААТАЙ ХАРЬЦАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

5.1. Шинжлэн шалгагчид нь агаарын хөлөгт аюултай ачаа ачиж явсан эсэхийг урьдчилан тогтоох ёстой. Ачааны дагалдах хуудас ба тээвэрлэгчтэй харьцаж асуулгаар үүнийг тогтооно. Аюултай зүйлд радио идэвхт бодис, тэсрэмтгий бодис, галт зэвсэг, идэмхий шингэнүүд, шингэн юмуу хатуу хор бактери зэрэг орж болно.

5.2. Радио идэвхт бодисыг агаарын хөлгөөр тээвэрлэж байсан бол ослын үлдэгдэлд ойрхон ажиллаж байгаа ажилтнуудад учирч болох аюулаас өмнө тэдгээрийг мэргэжлийн хүмүүс нэн даруй зайлуулах арга хэмжээ авах шаардлагатай. Агаарын хөлөгт тээвэрлэхийг зөвшөөрсөн радио идэвхт бодисын хэмжээний хязгаарлалт, баглаа боодол ба хаалтны найдвартай байдалд нь агаарын хөлгийн ослын үед хор хохирол учруулах магадлалыг бууруулна. Баглаа боодол ба хаалт нь бүрэн бүтэн байгаа тохиолдолд цацраг идэвхт бодисын хор уршиг бага байх магадлалтай. Гэвч ослын дараахь гал түймэр баглаа боодол ба хаалтыг гэмтээж энэ үед үүсэх өндөр температурын улмаас радио идэвхт бодис хийн хэлбэрт шилжиж тархах боломжтой. Энэ тохиолдолд аврах ба галтай тэмцэх ажиллагаанд оролцож байгаа бүх хүмүүсийг шалгаж ариутган шаардлагатай бол эмнэлгийн үзлэгт хамруулах шаардлагатай. Цацраг идэвхийн түвшинг шалгаж ослын газрыг аюулгүй гэж зарлахаас өмнө ослын үлдэгдлийн шалгалтыг эхлүүлж болохгүй.

5.3. Агаарын авиачимийн ажил гүйцэтгэж байсан агаарын хөлгийн осол нь ослын шинжлэн шалгагчдыг шавьжны хор хэлбэртэй аюултай материалын нөлөөнд өртүүлэх боломжтой. Цөөн хэдэн бодисоос бусад ийм бодисууд нь

бага хэмжээтэй байсан ч хортой байдаг. Ослын газарт хамгаалалтын хэрэгсэл ба тохиромжтой шүүлтүүр бүхий нүүрний маскыг хэрэглэх шаардлагатай.

## 6. ОСЛЫН ҮЙЛДЭГДЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

6.1. Ослын үлдэгдэлтэй харьцах нь заавал аюултай байдаг бөгөөд энэ үед хамгаалалтын хувцас ба тохирох хэрэгслийг хэрэглэх шаардлагатай.



6.2. Ослын үлдэгдэл хөдлөх, өнхрөх, модонд дүүжлэгдэх боломжтой учраас хөдөлгөөнгүй бэхлэх шаардлага гарч болно. Ослын үлдэгдлийн том хэмжээтэй хэсгүүдийг шинжлэн шалгагчид хяналтандаа байлгаж мэргэжлийн хүмүүс тохирох төхөөрөмжийн тусламжтайгаар гадагш зөөх ёстой. Үүнийг ялангуяа өргөгч цамхаг хэрэглэх үед анхаарах шаардлагатай. Энэ тохиолдолд шинжээчид нь хөө тортог, болон бусад агаараар дамждаг бодисуудын нөлөөнд өртөхгүйн тулд ослын үлдэгдлийн салхины дээд талд байвал зохино. Ямар нэг шалтгаанаар ослын үлдэгдлийн зарим хэсэг нь өлгөгдсөн байдалтай хэвээр байгаа бол кабель юм уу гинж тасарч ослын үлдэгдэл хөдөлгөөнд орохоос сэргийлж түүний доор юм уу ойролцоо ажиллахыг хориглоно.

6.3. Ослын үлдэгдэлтэй холбоотой өндөр даралттай сав, дохионы гэрэл, генератор, аккумулятор зэрэг олон аюултай зүйлс байдаг. Өндөр даралттай саванд хүчилтөрөгчийн сав, ослын гарцын агаарын сав, гал утраагч, хамгаалалтын амьсгалах хэрэгсэл орно. Хатуу хэлбэртэй хүчилтөрөгчийн

генераторууд нь идэвхжсэн үедээ 400 с хүртэл халдаг. Эдгээр бүх зүйлийг аюулгүй болгож ослын газраас зайлуулах шаардлагатай.

6.4. Дугуй нь агаарын хөлөг цохигдох юм уу хүчтэй газардах үед гэмтэж хэдийд ч буудах аюултай. Дугуй руу урд талаас нь юм уу ард талаас нь ойртох аль болохоор хийг түргэн гаргах ёстой.

6.5. Зарим сэнс нь тэвхэгдсэн пүрштэй байдаг ба бул нь цуурвал хүчтэй мултарч болно. Шинжлэн шалгагч нь сэнсийг задлах гэж оролдох ёсгүй. Сэнсийг задалж шалгах гэж оролдох ёсгүй. Сэнсийг задалж шалгах ажлыг зохих тоног төхөөрөмжөөр тоноглогдсон газарт гүйцэтгэвэл илүү зохино.

6.6. Аккумуляторыг салгаж ослын газраас гарах шаардлагатай. Оч нь асгарсан түлш ба бусад шатамхай материалуудыг гал авалцуулах аюултай учраас аккумуляторуудыг салгах ба зөөхдөө болгоомжтой байх ёстой. Мөн аккумулятор маш идэвхий чанартай байдаг.

6.7. Шатамхай шингэн ба хий нь гал авалцах юм уу тэсрэх аюултай. Түлшний уур нь амьсгалын замаар орох юм уу арьсанд шууд хүрэлцэх нь хортой. Агаарын хөлгийн түлшийг юулж, юүлсэн түлшний хэмжээг тэмдэглэж авах ёстой. Ослын газар тамхи татахыг хориглоно.

6.8. Ийм төрлийн бараа агаарын хөлөгт байж болох ба тэдгээрийг мэргэжлийн хүмүүс гаргах ёстой.

6.9. Цэргийн агаарын хөлөг нь салдаг суудал, зэр зэвсэг, пиротехник сум хэрэгсэл ачсан байж болно. Тэдгээр нь мөн онцгой буюу хүнд метал гидразин болох шатах үедээ аюултай бусад бодисуудыг ачсан байж болно. Сум хэрэгслийн мэргэжилтнүүд тэдгээрийг идэвхгүйжүүлж ослын газраас гаргах ёстой.

6.10. Хөө тортог ба тусгаарлагч материал нь кабин юм уу ачааны сав зэрэг битүү газар байвал аюултай. Ийм газар ажиллахдаа нүүрний маск ба нүдний хамгаалалтыг хэрэглэх ёстой.

6.11. Нийлмэл материалууд нь голдуу нүүрстөрөгч, бал чулуу юм уу вольфармаас тогтдог ба агаарын хөлгийн гадаргуу, хяналтын гадаргуу, хяналтын самбар, кабины материал, кабины суудал, ротор ба сэнсний далбаа зэрэг олон хэсэгт хэрэглэгддэг. Зарим агаарын хөлөг тэр чигээрээ нийлмэл материалаар хийгдсэн байдаг. Шилэн мяндсыг дуу нэвтрүүлдэггүй давхарга, бүхээг, кабины самбар, ачааны савны доторлогоо болон бусад тоноглуудад хэрэглэгддэг. Нийлмэл материал ба шилэн мяндас нь нүд, арьс, амьсгалын систем, ялангуяа ослын үлдэгдэл галд өртсөн бол аюултай байдаг. Ослын үлдэгдлийн нийлмэл материал ба шилэн мяндастай харьцах үедээ шинжлэн шалгагчид нь салхины дээд талд байх ба нүдний шил, нүүрний маск зүүх замаар мяндасны тоосноос өөрсдийгөө хамгаалах шаардлагатай.

6.12. Нэг удаа хэрэглэдэг хамгаалалтын цув шаардлагатай байж болно. Бохирдсон хувцсыг тусад нь угаах шаардлагатай.

6.13. Хагарсан шилэн мяндсан хавтан ба нийлмэл материалын хэлтэрхий нь гэмтэл учруулах аюултай учраас бээлийтэй харьцах ёстой.

6.14. Нийлмэл ба шилэн мяндсан материал нь галд гэмтсэн бол тэдгээрийг усаар шүрших юм уу боломжтой бол акрил лав ба усны 50 хувийн уусмалаар шүрших шаардлагатай.

## **7. БИОЛОГИЙН АЮУЛТАЙ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

7.1. Шинжлэн шалгагчид нь биологийн аюул тэр дундаа дархлал хомсдлын хам шинж ба гепатитын вирус зэрэг цусаар дамждаг өвчин үүсгэгч вирусаар халдварлах аюулд өртөх магадлал ихтэй. Биологийн аюул нь бүхээг ба кабины үлдэгдэл болон цогцос, амьд үлдэгдсийг тавьсан газраас дамжих боломжтой. Халдвартай цус ба бусад биеэс ялгарах шингэнүүдийг шууд мэдэх боломжгүй учраас ослын үлдэгдэл дотор юм уу түүний ойролцоо ажиллах, ослын газар ослын үлдэгдэлтэй ажиллах, ослын газраас гадуур ослын үлдэгдэлтэй хүртэлцэх шалгахдаа болгоомжтой байх ёстой.

7.2. Вирус салстлаг мембрин /нүд, хамар, ам/ юм уу зүссэн шарх, тууралт зэрэг арьсны эрүүл бус хэсгээр дамжин орохоос сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай. Ослын газарт шингэн, хагас шингэн, хатсан цус, бусад биеэс ялгарах шингэн, ясны хугархай биеийн эд ба дотоод эрхтнүүд байж болно.

7.3. Ослыг шинжлэн шалгах ажлын төлөвлөгөөний хүрээнд зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Шинжлэн шалгагчид ба ослын газар мөн ослын газраас гадуур ослын үлдэгдлийн шалгалт, шинжилгээ явуулж байгаа биологийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалтанд хамрагдаж В гепатитын эсрэг вакцин хийлгэсэн байх ёстой.

7.4. Хамгаалалтын хэрэгслийг ослын үлдэгдлийг ослын газраас гадуур шинжлэн шалгах үед хэрэглэх шаардлагатай байж болно. Биологийн аюулаас зохих шаардлагын дагуу хамгаалах сургалт ба төхөөрөмжийн асуудлаар мэргэжлийн байгууллагад хандаж тэдгээрээр хангуулах арга хэмжээг авна.

7.5. Латекс /резин нимгэн/ бээлийн дотуур өмсөх боловч тэдгээр нь эдэлгээ даахаар байх ёстой. Бүх латекс бээлийнүүдийг ослын газрыг орхин явахын өмнө шаардлагын дагуу хаях ёстой.

7.6. Ажлын бээлий нь эдэлгээ сайтайгаас гадна хэрэглэхэд тохиромжтой байх бөгөөд гар ба бугуйг хатгуулах, шалбархайгаас хамгаалах ёстой. Арьс, нитрил, кевлар, бээлийг түгээмэл хэрэглэнэ. Эдгээр гурван төрлийн бээлийг бүгдийг нь ариутгах эсвэл ослын газар явахаас өмнө зохих шаардлагын дагуу хаях ёстой.

7.7. Нүүрний маск нь хамар ба амыг хаасан байх ёстой. Маск нь нэг юм уу олон дахин хэрэглэх зориулалттай байж болох ба тэдгээрийг ариутгах юм уу ослын газраас явахаас өмнө зохих шаардлагын дагуу хаах ёстой.

7.8. Хамгаалалтын нүдний шил нь нүдний дээд, доод, хажуу талуудыг битүүлэн нүдийг бүрэн хаасан байх ёстой. Ердийн хөдөлмөр хамгааллын шил шаардлага хангахгүй. Нүдний шил нь цантахаас сэргийлсэн зөвхөн гадагшаа агаар гардаг клапантай байх ёстой ба түүнийг ариутгах юм уу ослын газраас явахаас өмнө зохих шаардлагын дагуу хаях ёстой.

7.9. Нэг удаагийн хамгаалалтын хослол нь эдэлгээ сайтай, шингэн нэвтрүүлдэггүй бөгөөд биед таарсан байх ёстой. Боломжтой бол сунадаг юүдэн ба өмдний түрийтэй байх ёстой. Хамгаалалтын хослолыг өөрчлөх юм уу урагдсан хэсгийг нөхөхдөө резин ашиглаж болно.

7.10. Пластмас юм уу резинээр хийсэн нэг удаагийн улавчийг хэрэглэх нь тохиромжтой. Арьс, резин ажлын гутал хэрэглэж болно. Нэг удаагийн улавч ба хамгаалалтын гутлыг ариутгах юм уу ослын газраас явахаас өмнө зохих шаардлагын дагуу хаях ёстой.

7.11. Хувийн хамгаалалтын хэрэгслийг ариутгахад хоёр төрлийн химийн бодисыг өргөн хэрэглэдэг. Спиртийн 70 хувийн уусмал үр дүнтэй бөгөөд жижиг болон том гарын алчууранд шингээсэн байдлаар байдаг. Хамгийн үр дүнтэй ариутгалын уусмал ба ердийн ахуйн хлорамин ба усны аравны нэгийн харьцаатай уусмал юм. Спирт ба хлораминийг хэзээ ч хольж болохгүй.

7.12. Биологийн аюултай бодисын уутыг бохирдсон хувийн хамгаалалтын хэрэгслийг хаяхад хэрэглэх ёстой. Уут нь улаан юм уу улбар шар өнгөтэй ба биологийн аюултай гэсэн шошготой байх ёстой. Тээвэрлэх үед хаягдал материалыг давхар уутанд хийсэн байвал зохино.

7.13. Ослын газар мөрдөх ёстой журамд эхлээд ил харагдах цус ба бусад биеэс ялгарах шингэнийг ажиглах заалтыг оруулна. Ноцтой гэмтэл юм уу золгүй явдал тохиолдсон бол нас барсан ба гэмтсэн хүмүүсийг холдуулсны дараа биеэс ялгарсан шингэн илрэх нь элбэг байдаг. Цус ба биеэс ялгарсан шингэнээр бохирдсон хэсгийг илрүүлж тусгаарлан зөвхөн нэг гарах гарцтай болох ёстой. Зөвхөн хувийн хамгаалалтын хэрэгсэлтэй хүмүүсийг бохирдсон газарт нэвтрэхийг зөвшөөрөх ёстой. Шинжлэн шалгах зорилгоор ослын газраас авч явсан ямар ч зүйлтэй ослын газарт байгаатай ижил болгоомжтой ажиллах ёстой.

7.14. Шинжлэн шалгагчид нь үргэлж хүний биеийн эд ба биеэс ялгарах шингэн нь халдвартай гэж үзэн цус болон бусад шингэн зүйл бүхий ослын үлдэгдлийг шалгах явцдаа маск ба ажлын бээлийний дотуур латекс бээлий хэрэглэх ёстой. Хамгийн түгээмэл бохирдсон зүйлүүд бол кабины бүх дотор материалууд, суудлын ба мөрний даруулга, суудлын зөөлөвч, бусад бүрээс ба эмжээрийн материалууд, удирдлагын самбар байдаг. Биологийн аюултай бүсэд хувийн хамгаалалтын хэрэгсэл хэрэглэж байгаа үедээ шинжлэн шалгагчид нь ууж идэх, тамхи татах, нүүр ба уруулаа будах, нарны тос түрхэх, нүүр, нүд, хамарт хүрэх юм уу контакт линзээ оролдох зэргийг хориглоно.

7.15. Хувцас, бохирдсон хувийн хамгаалалтын хэрэгсэл гэх мэт биологийн аюултай хаягдлыг зайлуулах шаардлагатай. Шинжлэн шалгагчид нь эхлээд гадуур ажлын бээлийг тайлаад латекс бээлийг тайлуулж хоёуланг нь биологийн аюултай хаягдлын уутанд хийнэ. Бохирдсон хувийн хамгаалалтын хэрэгслийг дахин хэрэглэх ёсгүй. Бохирдсон зүйлд хүрсэн арьсыг нэн даруй чийгтэй алчуураар арчаад савантай ус юм уу арван хувийн хлорамины уусмалаар угаана. Өдөр бүр нэг шинэ лонх хлорамины уусмал бэлдэж байх ёстой. Бохирдсон нүдийг цэвэр усаар шавшина. Латекс бээлийг тайлсны дараа ба идэх, уух, тамхи татах, контакт линзэнд хүрэхийн өмнө гарыг сайтар угаахад онцгой анхаарах ёстой.

7.16. Шинжлэн шалгагчид нь халуун ба чийгтэй цаг агаарын нөхцөлд хувийн хамгаалалтыг хэрэглэх нь халуун, цаг агаарын нөлөөг багасгах урьдчилсан арга хэмжээ авахгүй бол наранд цохиулах аюултай гэдгийг ойлгох ёстой. Иймээс хувийн хамгаалалтын хэрэгсэл өмсөхөөс өмнө нэг литр буюу түүнээс дээш хэмжээний ус уух ёстой. Халуун ба чийгийн хэмжээ мөн биеийн хүчний ажлын хэмжээнээс хамаарч шинжлэн шалгагчдын хувийн хамгаалалтын хэрэгсэл хэрэглэх хугацааг хязгаарлах шаардлагатай байж болно. Тэд биологийн аюултай бүсээс гаран хувийн хамгаалалтын хэрэгслийг устгаж гараа ариутгасны дараа шинжлэн шалгагчид сүүдэрт амарч дор хаяж нэг литр ус уух ёстой. Халуунд ажилласан шинжлэн шалгагчдын биеийн байдлыг эмнэлэгийн ажилтнууд үзэх шаардлагатай байж болно.

7.17. Бохирдсон материалтай шууд хүрэлцэж буй шинжлэн шалгагчид нь багаж хэрэгслийн тоог цөөрүүлэх нь чухал учраас зөвхөн сонгосон тодорхой тооны шинжлэн шалгагчид ослын үлдэгдэлтэй ажиллаж эд ангиудыг задлах ёстой. Бусад шинжлэн шалгагчид нь тэмдэглэл хөтлөх, зураг зурах, фото зураг авах юм уу заавар ба инженерийн зураг ашиглах зэрэг ажил гүйцэтгэж болно.

7.18. Багаж хэрэгсэл, гар чийдэн, туузан метр зэрэг бохирдсон шинжилгээний төхөөрөмжүүдийг савантай усаар угааж ариутган хатаах ёстой. Шууд ариутгах боломжгүй төхөөрөмжүүдийг биологийн аюултай хаягдлын уутанд хийнэ. Хаягдлын уут ба дотор байгаа зүйлсийг эмнэлэг зэрэг зохих газар шатаах ёстой.

## **8. НИСДЭГ ТЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

8.1. Нисдэг тэрэгний ажиллагаатай холбоотой бүх хүмүүст аюулгүй ажиллагааны заавар тэр дундаа гарц, чихэвч, бэхэлгээний систем, ослын төхөөрөмж ба усан дээгүүр ажиллагаа явуулж байгаа үед хөвөх хэрэгслийн ашиглалтын талаар товч зааварчилгаа өгөх ёстой. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа нь мөн нисдэг тэрэг, үндсэн ба арын сэнсийн аюул, сэнсний урсгалын нөлөө зэргийг хамрах ёстой.

## 9. БАЙГАЛЬ ОРЧИНЫ БОЛОН ЦАГ АГААРЫН АЮУЛТАЙ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

9.1 Байгаль орчны аюулд эрс тэс уур амьсгал, уулархаг нутаг, цөл, жунгаль, намаг балчиг хортой ургамал, аюултай амьтад ба шавьж орно. Ийм орчинд шинжлэн шалгагчид нь хосоороо анхны тусламжийн иж бүрдэл ба холбооны хэрэгсэлтэй ажиллах ёстой.

9.2. Шинжлэн шалгагчид нь газар нутаг ба жилийн улирлаас шалтгаалж хэт халуун юм уу хүйтэн нөхцөлтэй тулгарч болно. Алс хязгаар нутагт хэдэн цагийн турш ажиллах ёстой шинжлэн шалгагчид нь тээврийн хэрэгсэл буцах боломжгүй болсны улмаас шөнийг хээр өнгөрөөх шаардлагатай болж болно. Иймээс аялалд гарахын өмнө цаг агаарын тухайн үеийн болон урьдчилсан мэдээг сонсох шаардлагатай.



Хүйтэн цаг агаартай үед дараахь урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд хөлдөх ба наршихаас хангалттай хамгаалах хэрэгсэл ашиглана. Хөлс шингээх боломжтой давхар үетэй хувцас өмсөнө. Цасан шамаргатай үед орчны бүх зүйл цагаан болсноор орон зайны баримжаа алдах боломжтой байдгийг анхаарна. Нарны шил ба нарны хаалт хэрэглэнэ. Биеийн шингэнээ алдахаас сэргийлж шингэн зүйл их ууна.

9.3. Халуун цаг агаартай үед дараахь урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд Өөрийн ундны хэрэгцээг хангах хангалттай шингэн зүйл авч явна. Өндөр температур ба чийг нь хүнд ажилтай хавсарсан үед цаг тутам дор хаяж хагас литр ус юм уу шингэн зүйлс ууна. Халуунд туйлдах юм уу наранд цохиулах шинж тэмдэгийг мэддэг байна. Нарны тос хэрэглэнэ.

9.4. Өндөр өргөгдсөн газар ажиллах үед гардаг гол хүндрэл бол толгой эргэх, толгой өвдөх, хоолны дуршилгүй болох, нойр муудах, бие өвдөх нүүр цонхийх тамиргүй болох зэрэг шинж тэмдэгээр илэрдэг өндрийн өвчин юм. Эрч хүчээ гамнахын тулд ажлын эрчийг тохируулах ёстой. Өндрийн өвчний шинж тэмдэг илэрвэл суух юм уу хэвтэх хэрэгтэй. Ноцтой нөхцөлд нэн даруй илүү нам газар луу шилжин байрлах шаардлагатай.

9.5. Далайн түвшнээс дээш 3000 метр буюу 8000 футээс илүү өндөрт биеийн хүчний ажлын ачааллыг багасгана. Өндөр газар хүчилтөрөгч бэлэн байлгана. Биеийн шингэнээ алдахаас сэргийлж ус юм уу шингэн үйлс ууна. Нарны хаалт, нарны шил малгай хэрэглэнэ. Орон нутгийн газарчдаас хэн шинжлэн шалгах багтай хамгийн тохиромжтой талаар зөвлөгөө авна.

9.6. Ослын газар нь цөл, ширэнгэн ой, намгийн орчим байрлалтай бол өргөн хүрээтэй малгай, сул хувцас, нарны шил, нарны хаалт, хамгаалалтын шил хэрэглэнэ. Ундны ус ихээр авч явна. Өдрийн халуун үед ажлын ачааллыг багасгаж хажуугаараа онгорхой нарны сүүдрэвч босгоно. Орон нутгийн жолооч нарын хөлсөлнө. Элсэн манхан ба таних тэмдэггүй замаар дөрвөн дугуйгаараа мааждаг машинаар явсан ч гэсэн аюултай. Шөнө хүйтрэх үед тохиромжтой хувцас ба оромж бэлэн байлгана. Хануур хорхой, шавьж, мөлхөгчдөөс хамгаалахын тулд өмдний шуумаг ба гутлын түрийг резин, уяа, туузаар бэхлэнэ. Багийн бусад гишүүнтэй холбоотой байна. Ажлын ачааллыг багасгах замаар халуун ба чийгээс сэргийлнэ.

9.7. Намгийн завийг тээврийн хэрэгсэл болгон ашиглаж байгаа бол хамгаалалтын хүрэм ба чихэвч зүүнэ. Ус туулж байгаа нөхцөлд усны гутал өмсч хөлөө гишгэх тулгуур олж усны түвшинг тогтоохын тулд урт саваа ашиглана. Намагны ус иш бохирдсон байж болох учраас биеийн зүсэгдсэн хэсэг ба шарханд шууд хүрэхээс сэргийлнэ. Шавьж, хануур хорхой, могойноос сэргийлнэ.

## **10. ХОРТОЙ УРГАМАЛ, АЮУЛТАЙ АМЬТАД БА ШАВЬЖТАЙ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

10.1. Ургамал, амьтад ба шавьжны учруулж болох аюул нь газар нутаг, цаг агаар, газрын өргөгдөл, жилийн улирал гэх мэт хүчин зүйлүүдээс шалтгаалдаг ба энэ талаар орон нутгийн мэргэжилтнүүдийн зөвлөгөөг авах шаардлагатай.

10.2. Ихэнх зэрлэг амьтад хүнтэй тулахаас зайлсхийдэг боловч зарим нэг аюултай амьтад байдаг ба шинжлэн шалгагчид нь орон нутгийн мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөгөөг үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай. Хортой могой олон газар тархмал байдаг ба могойн хорноос хамгаалах ийлдэс шинжээчдийн анхны тусламжийн хэрэгсэлд байх ёстой.

10.3. Олон газар шумуул нь хумхаа ба хижиг өвчнийг халдаадаг "DEET"-ийн 25-30 хувийн уусмал бүхий аливаа бүтээгдэхүүн нь шумуулнаас үр дүнтэй хамгаалах хэрэгсэл болдог. Гэхдээ 30 хувиас дээш концентрацитай бол арьсыг

цочроож болно. Ийм төрлийн шумуул үргээх бүтээгдэхүүн зургийн аппарат, цаг, жижиг багаж, зэрэг зүйлүүдэд байдаг хуванцарыг хайлуулж болох бодис агуулдаг гэдгийг анхаарах шаардлагатай. Хумхаа ба хижиг өвчин түгээмэл гардаг газар ажиллаж байгаа хэн ч гэсэн хумхааны эсрэг эм авч явах ба хижгийн вакцин хийлгэсэн байх шаардлагатай.



10.4. Хээр тал ба ойд амьдардаг хачиг өвчин халдварласан хачигт хазуулсны улмаас үүсдэг Лимийн өвчин зэрэг бактерийн өвчин халдааж болно. Хачиг ихтэй газар ажиллах үедээ урт шуумагтай өмд ба урт ханцуйтай цамц өмсөнө. Өмдний шуумагийг тууз юм уу резинээр хумина. Хувцсан дээрээ перметриний төрлийн хачиг үргээгч шүршинэ. Нүүрнээс бусад ил гарсан арьсан дээр нийлмэл DEET бүхий үргээгч цацна. Өдөр бүр бүх биеэ хачиг байгаа эсэхийг шалгана. Арьсан дээр байгаа хачгийг нэн даруй зайлуулна.

## **11. ХОТ СУУРИН ДАХЬ ОСЛЫН ГАЗАРТ АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨГДӨХ АЖИЛЛАГАА**

11.1. Хот сууринд гарсан ослын газар дахь, аюулд цахилгаан тасрах, байгалийн хий, нүүрс усны хий, халаалтын тос болон бусад шатамхай шингэн ба хий, галын юм уу цохилтын нөлөөгөөр тогтворгүй болсон арилга орно.

11.2. Ослын газар юм уу барилгад орохын өмнө боломжит аюулыг мэргэжлийн хүмүүс дүгнэх шаардлагатай байж болно.

## ЗААВАРЧИЛГААНЫ ХУУДАС

№	Урьдчилсан зааварчилгаа авсан хүний овог нэр	Зааварчилгын утга	Он, сар, өдөр	Зааварчилгаа өгсөн хүний нэр, гарын үсэг	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					

**ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, ХАМГААЛАХ  
ХЭРЭГСЭЛ**

Улирал	Дэс дугаар	Ердийн нөхцөл			Байгалийн хүнд нөхцөл			
		Нэр төрөл	Тоо, ширхэг	Хугацаа /жил/	Нэр төрөл	Тоо, ширхэг	Хугацаа	
							Ердийн /жил/	Осол /улаа/
ЗУН	1	Ялгах тэмдэг бүхий саравчтай, нарны малгай	1	3	Тусгай зориулалтын ажлын өмд, цамц /комбинзон/	1	3	1
	2	Ялгах тэмдэг бүхий богино куртка	1	3	Зун, хавар-намрын, гадны цохилтоос хамгаалагдсан, галд тэсвэртэй, бензин, тос, хүчил, шүлт үл нэвтрэх гутал	1	5	1
	3	Ажлын бээлий	4	1	Хамгаалалтын малгай /Каска/	1	5	0
	4	Хамгаалалтын нүдний шил	1	3	Борооны цув	1	5	1
	5	Резинэн бээлий	1	1	Усны гутал	1	5	1
	6	Чихний хамгаалалт	1	5	Амны маск	2	1 сар	Өдөр бүр
ӨВӨЛ	1	Ноосон малгай	1	3	Нэхий дотортой куртка	1	5	1
	2	Өвөл, хавар-намрын салдаг малгай, дотортой хагас куртка	1	3	Нэхий дотортой өмд	1	5	1
	3	Дулаан бээлий	1	1	Өвлийн халтиралт, цохилтоос хамгаалагдсан, галд тэсвэртэй, бензин, тос, хүчил, шүлт, ус үл нэвтрэх гутал	1	5	1

НТОЗШША



Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа



БАГАЖ ХЭРЭГСЭЛ



тоног төхөөрөмжийн сав



багажны сав



Шинжээчдийн хувийн багажны сав





шинжилгээний дээж авах сав



Шинжилгээний дээж авах уут



Багаж хэрэгсэл



Хэмжих хэрэгсэл



Байрлал тогтоогч



Богино долгионы хэрэгсэл



Холбоо



Дектафон



Нөөц зөөврийн компьютер



Фото аппарат





Бичлэг тайлах төхөөрөмж